



ТӨВ АЙМГИЙН СҮМБЭР СУМЫН ЦЭЦЭРЛЭГ

2013 оны Санхүүгийн Тайлан

Төв аймгийн Аудитын газар нь Төрийн Аудитын тухай хуульд заасан Аймгийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим холбогдох хууль, журам зааварт нийцүүлэн аудит хийж байна.

Аудитыг дуусгавар болгосон тухай тайлан

АГУУЛГА

ХУУДАС

Лавлах зүйлс байвал доорх хаягаар холбоо барина уу:

Үндэсний аудитын газрын харьяа Төв
аймгийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор
Л.Жаргалсайхан
Утас: 70272582
[И-мэйл](#)

СТА-ын ахлах аудитор
Ц.Базарсад
Утас: 70272287
И-мэйл Bazaraatsend@yahoo.com

ТӨАГ-ын хаягийг оруулах

Төв аймаг Зуунмод сум 1-р баг
Төрийн байгууллагуудын ордон

• Танилцуулга	4
• Санхүүгийн дотоод хяналт	4
• Гол шийдлүүд	7
• Залруулаагүй алдаа	7
• Тайлбар мэдүүлгийн захидал.....	7
• Өмнөх аудитын зөвлөмжийн биелэлт.....	7
• Аудитын санал дүгнэлт	8

Цэцэрлэгийн 2013 оны Санхүүгийн тайланд

ААГ аудит хийж дууссан тухай мэдэгдэл

Бид Цэцэрлэгийн 2013 оны Санхүүгийн тайланд аудитаа хийж бараг дуусаж байгаа ба цэцэрлэгийн төсвийн Ерөнхий менежерт энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаарх бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд цэцэрлэг тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.

Удирлагын зөвлөлийн анхаарлыг дараах зүйлд чиглүүлж байна:

- Гол санхүүгийн хяналтууд хамрагдсаныг **тодруулбал:**

НББ-ийн үе шат бүрд дээд шатны түвшний удирдлага хүрдэг эсэх, нийтлэг чанартай зардал, төсвийн санхүүжилт, өөрийн орлого, цалингийн зардал, өглөг, авлага, балансын үзүүлэлтүүд, үндсэн хөрөнгө, бараа материал, бусад асуудлуудыг хамруулсан бөгөөд байж болзошгүй эрсдлийг тооцож холбогдох батламж мэдэгдлүүд хэрхэн хангагдаж байгааг нотлох үүднээс холбогдох стандарт, журам зааврын дагуу шаардлагатай горимыг хэрэгжүүлсэн.

Гол илрүүлсэн зүйлс аудитын үр дүнгээс гарсныг тодруулбал:

1. Байгууллагын дотоод хяналтыг 2011.03.02-ны өдрийн 17 тоот тушаалаар батласан байна. Дотоод хяналт шалгалтыг явуулах журмыг батласан гэх боловч төлөвлөгөө удирдамж гарган хийсэн хяналт шалгалт байхгүй байна.
2. Халаалтын зардлыг нарийвчилан тооцож үзэхэд НРЖ-16 тогооны цагийн нормоор нь нүүрсийг тооцоход хэтрэлт гараагүй ажилласан байна.
3. 2013 онд нийт 19567 хүүхэд жилдээ 32199.5 мянган төгрөгний хоолны зардал гаргажээ. Энэ нь нэг хүүхэд өдөрт 1645,60 төгрөгний зардал гаргаж, Засгийн газраас тогтоосон нэг хүүхэд өдрийн хоолны зардал 1650 төгрөгнөөс 4.40 төгрөгөөр буюу жилдээ нийт 86.1 мянган төгрөгөөр дутуу хооллосон байна.
4. Үр дүнгийн тайланд НД-аас ХЧТА,ЖА тэтгэмжийн дамжсан

гүйлгээг орлогоор харуулж, зардалд бичсэн. Мөн орлогод 6713.8 мянган төгрөгний үнэ төлбөргүй авсан үндсэн хөрөнгийг орлогоор аваагүй, зардалд аймгийн төсөвт татсан 5000.0 төгрөгийг зардал харуулсаныг залруулсан.

5. Мөнгөн гүйлгээний тайлан орлого, зарлага талд 6510572 төгрөгний дамжсан гүйлгээг илүү тусгасан, Төсвийн гүйцэтгэлийн тайланд орлого талд дээрх 6510572 төгрөгийг илүү, зарлага талд 1510572 төгрөгийн илүү тусгасаныг залруулсан.
6. Сангийн сайдын 2013.12.02-ны өдрийн 269 тоот журмыг мөрдөж ажиллаагүй байна.

Шууд захирагчаас ААГ тайлбар мэдүүлэг хүлээж байгаа

-Илэрсэн алдааг хэрхэн залруулсан талаар тайлбар ирүүлнэ үү

- Аудитыг дуусгаж аудитын явцад олж авсан ажлын баримтанд үндэслэн зөрчилгүй санал дүгнэлт гаргахаар тэргүүлэх аудиторт санал оруулсан байгаа
- Аймгийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт 2014.03.14-ны өдөр санал дүгнэлтэнд гарын үсэг зурна.

Эцэст нь аудитын явцад Ерөнхий нягтлан бодогч М.Цэцгээ бидэнтэй хамтран ажилласан ажилчдын байнгын дэмжлэг туслалцаа бидний ажилд дэмжлэг болж байсанд гүнээ талархаж байна.

**Үндэсний Аудитын Газрын харьяа
Төв Аймгийн Аудитын Газар**

2014.03.14

Танилцуулга

1. Бид Аймгийн Сүмбэр сумын цэцэрлэгийн 2013 оны 12 дугаар сарын 31-р тасалбар болсон санхүүгийн тайланд аудитаа хийж бараг дуусаж байгаа ба Аймгийн Сүмбэр сумын цэцэрлэгийн ерөнхий менежерт энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаарх бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд Сүмбэр сумын цэцэрлэг тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.
2. Бидний 2013 онд тайланд хийсэн аудит нь 2 гол элементтэй:
 - Санхүүгийн хяналтын системийг дахин шалгах;
 - Жилийн санхүүгийн тайланд аудит хийх.

Аудитаас үүдэн гарсан асуудлууд дараах хэсэгт хураангуйлагдсан.

Жилийн санхүүгийн тайланд аудит хийхэд

3. ААГ санхүүгийн хяналтыг дахин шалгаж үзээд санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг баталгаажуулах шаардлагатайг авч үзсэн. Бидний дахин шалгалт нь Аймгийн Сүмбэр сумын цэцэрлэгийн хяналтыг ААГ-ын санхүүгийн эрсдэл ба хяналтын мэдээтэй харьцуулан шинжлэн үзсэн. Үүний үр дүнд цаг ямагт үр өгөөжтэй материаллаг алдаанаас сэргийлж чадах гол санхүүгийн хяналтыг онцгойлон үзсэн юм. Бид Аймгийн Сүмбэр сумын цэцэрлэгийн эрхлэгчид тухайн жилийн эдгээр хяналтын асуудлын тухай тайлагнасан.

4. Дараахь түвшний хяналтын асуудал бидний дахин шалгалтын үр дүнгээс гарсан бөгөөд үүнд Аймгийн Сүмбэр сумын цэцэрлэгийн удирдлагын анхаарлыг хандуулж байна:

1. Санхүүгийн дотоод хяналтын талаар

2013.11.1-ний өдрийн 23 тоот тушаалаар Дотоод хяналтын бүрэлдэхүүн томилсон боловч төлөвлөгөө удирдамж гарган хийсэн хяналт шалгалт байхгүй байна.

2. Орлогын талаар

2013 онд төсвөөс 179792.2 мянган төгрөгний санхүүжилт авахаас санхүүжилтийг бүрэн авчээ.

3. Мөнгөн хөрөнгийн талаар

Үр дүнгийн тайланд НД-аас ХЧТА,ЖА тэтгэмжийн дамжсан гүйлгээг орлогоор харуулж, зардалд бичсэн. Мөн орлогод 6713.8 мянган төгрөгний үнэ төлбөргүй авсан үндсэн хөрөнгийг орлогоор аваагүй, зардалд аймгийн төсөвт татсан 5000.0 төгрөгийг зардал харуулжээ.

Мөнгөн гүйлгээний тайлан орлого, зарлага талд 6510572 төгрөгний дамжсан гүйлгээг илүү тусгасан, Төсвийн гүйцэтгэлийн тайланд орлого талд дээрх 6510572 төгрөгийг илүү, зарлага талд 1510572 төгрөгийн илүү тусгажээ

2013 оны эхний 9 сарын байдлаар зардлуудыг холбогдох баримт, нэхэмжлэхтэй нь тулгахад цэцэрлэг 2012 оны 12 сарын 18-ны өдрийн 973.4 мянган төгрөгийн нүүрсний үнийг 2012 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй, 2013 оны 2 сарын 07-нд шилжүүлж, бараа материалд орлого авч зарлагадсан байна. Энэ нь Монгол Улсын Нягтлан Бодох Бүртгэлийн тухай хуулийн 9.4 “аж ахуйн нэгж,

байгууллага нь хөрөнгө, өр төлбөрөө нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэлж дансанд тусгана” гэсэн заалтыг зөрчсөн байна.

2 сарын 04-ний өдрийн 136.5 мянган төгрөгийн махны гүйлгээг мөнгөн гүйлгээ болон бараа материалын журналд бичилт хийсэн байхад няравын тайалнд 2 сарын 28-нд орлогод авч зарлагдсан нь баримтын гүйлгээ зөрүүтэй, түүнд тавих хяналт муу байна.

1 дүгээр улирлын байдлаар нүүрс модны үлдэгдэлгүй тайлагнасан, мөн түлээний модыг орлогод авах зарлага болгохдоо хэмжих нэгжийг куб метрээр тооцдоггүйгээс портер модыг харилцан адилгүй үнээр авдаг, авсан модны хэмжээ тодорхойгүй байгаад эрсдлийн аудитаар зөвлөмж өгсөний дагуу сүүлийн улиралд м3-ээр нь хэмжиж авсан байна.

Бараа материалын журналаар албан бичиг, бланкыг дамжуулан бичилт хийлгүй шууд зарлагад бичсэн, 4 сард 36.6 мянган төгрөгийн шатахууныг төрийн сан зөрүүтэй тайлагнасан, Хүнсний ногоо, сүүний үнийг урьдчилан төлж авлага үүсгэлгүй бараа материалын журналд бичилт хийсэн, няравын бараа материалд орлогод авсан байна.

Аймгийн 90 жилийн ойн арга хэмжээнд зориулж 300.0 мянган төгрөгийн зардлыг хичээл үйлдвэрийн зардлаас зориулалт бус зардал гаргасан байна.

Цэцэрлэг хүүхдийн хоолны дээжийг хөргөгч эвдэрсэн гэх шалтгаанаар зориулалтын бус саванд хадгалж байлаа.

Нүүрсийг нарийн бүртгэдэггүй, ирсэн нүүрсний орлогыг бүрэн авдаггүй, мөнгө шилжсэн хэмжээгээр орлого авдаг, зарцуулалтыг нарийн тайлагнадаггүй зэрэг дутагдлууд байсаар байна.Цаашид жилийн эцсээр бүртгэл тайлагналтыг цаг тухай бүрд нь бүрэн хөтөлж, складын бүртгэлийн бүрэн хөтөлж хэвшүүлэхийг зөвлөсөн.

4. Бараа үйлчилгээний талаар

Гэрэл цалилгаан, түлш, халаалт, цэвэр бохир усны зардалд нийт 12 697.9 мянган төгрөгний зардал батлагдсан гүйцэтгэлээр 12697.9 мянган төгрөгний зардал гаргажээ. 4-р бүлгийн хэвийн үйл ажиллагаа хангах зардалд нийт 906.1 мянган төгрөгний зардал батлагдсанаас 906.1 мянган төгрөгний зардал гаргасан байна.

5-р бүлэг эд хогшлын 958.1 мянган төгрөгний зардал батлагдсаныг батлагдсан хэмжээнд зарцуулжээ.6-р бүлэгт томилолтын 170.0 мянган төгрөгний зардал батлагдсан, зардлыг батлагдсан хэмжээнд зарцуулжээ.7-р бүлэгт 657.1 мянган төгрөгний зардал батлагдсаныг батлагдсан хэмжээнд бүрэн зарцуулжээ. .

Хоолны зардалд 32298.9 мянган төгрөгний зардал батлагдсан, гүйцэтгэлээр 32298.9 мянган төгрөгний зардал гаргаж, батлагдсан зардлыг бүрэн зарцуулжээ. Хүүхдийн хоолны зардлыг Засгийн газраас баталсан нормоор зарцуулжээ.Эмийн зардалд 55.1 мянган төгрөгний зардал батлагдсаныг батлагдсан хэмжээнд зарцуулжээ.Хичээл практикийн зардалд 694.5 мянган төгрөгний төсөвт зардал батлагдсаныг бүрэн зарцуулсан байна

5. Бараа материалын талаар

2013 онд 44511.1 мянган төгрөгний бараа, материал төсвийн хөрөнгөөр худалдан авч, 404.9 мянган төгрөгний бараа, материал үнэ төлбөргүй авчээ. 42918.4 мянган төгрөгний бараа, материал үйл ажиллагаандаа зарцуулжээ. 2431.9 мянган төгрөгний бараа материалыг данс хооронд шилжүүлснээс 368.1 мянган төгрөгийг материалын данс хооронд, 2063.8 мянган төгрөгийг үндсэн хөрөнгөнд шилжүүлсэн байна.

Бараа, материалын данснаас 656.0 мянган төгрөгний бараа, материалыг актлаж данснаас хассан байна. Гэвч сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хөрөнгө актлах шийдвэр 2014.2.7-нд гарчээ.

Хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, складын эмх цэгц, ашиглалтын байдлыг газар дээр нь тулган баталгаажуулахад хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг бүртгээгүйгээс эд хариуцагчийн бүртгэлийн карт нь эзэмшиж буй хөрөнгөтэй зөрүүтэй байлаа.

Цэцэрлэг, соёлын төвийн агуулах стандартад нийцэхгүй, хаягжуулж төрөлжүүлээгүй байна.

Цэцэрлэг нярав солигдоход тооллогоо хийж, акт үйлдээгүй ба энэ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 11.2 “эд хөрөнгийн тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ. 11.2.2 “эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой ажилтан солигдох үед” гэсэн заалтыг зөрчсөн.Эрсдлийн аудитаар хүнсний материалд тооллого хийж тооцоо бодоход 6 нэр төрлийн 214.5 мянган төгрөгийн материал дутагдаж, 5 нэр төрлийн 36.8 мянган төгрөг материал илүүдэж акт бичигдэж бүрэн төлөгдсөн.

Мөн өөрсдийн ажилчдын хүчээр төмс тариалж хураан авсан боловч түүнийг өнөөдөр орлого аваагүй, зардлаа нөхөөд үлдсэнийг нь авна гэсэн байдлаар идсэн хэмжээгээрээ орлого авч байна.

Ногоо хадгалах зоорь байхгүйгээс тооллогоор байцаа 321кг буюу 160.5 мянган төгрөг, төмс 51 кг буюу 17.8 мянган төгрөг, манжин 60.5кг буюу 36.3 мянган төгрөг ногоо дутагдсан шалтгааныг айлын зооринд хадгалуулсан гэж тайлбарлаж байгаа.Энэ нь сумын 40 тн-ийн зоорийг одоо хүртэл ЗДТГ-ын мэдэлд ирээгүйгээс төсвийн байгууллагууд ногоогоо хадгалах зоорьгүй байна.

Байгууллагын складанд тамгын газрын тусламжаар ирж тараагдаж байсан ашиглах боломжгүй 150 кг гурил хадгалж байсаныг хариуцсан хүнд нь өгөх буюу устгах асуудлыг шийдвэрлүүлэх талаар зөвлөгөө өгөгдсөн.

Жилдээ нийт 73.28 кг буюу 8175.4 мянган төгрөгийн нүүрсний орлого авч, 55.64 кг буюу 6105.6 мянган төгрөгний нүүрс зарцуулж, эцсийн үлдэгдэл 17.64 кг буюу 2069.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.НРЖ-10 тогооны нормоор бодоход 8 сарын галлагаанд цагт 16 кг буюу хоногт 384 кг-р тооцвол 92.16 кг-ийг зарцуулахаар байхад 55.64 кг-ийг хэрэглэж 36.52 кг-ийн хэмнэлттэй зарцуулсан харагдаж байна.

6. Үндсэн хөрөнгийн талаар

2013 оны эхний үлдлэгдэл 183876.9 мянган төгрөг, хандив тусламжаар үнэ төлбөргүй 4650.0 мянган төгрөг, бараа материалын данснаас шилжиж ирсэн 2063.8 мянган төгрөг нийт 6713.8 мянган төгрөгний үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй нэмэгдсэн, хасагдсан үндсэн хөрөнгө байхгүй, эцсийн үлдэгдэл 190990.7 мянган төгрөг байна.Эрхлэгчийн 2013.12.11-ний өдрийн а/24 тоот тушаалаар тооллогын комисс томилогдож, тооллого хийжээ.Тооцоо бодож акт үйлдсэн байна.

7. Авлага, өглөгийн талаар

Оны эхэнд 5000.0 мянган төгрөгний авлага байсныг бүрэн барагдуулсан байна. Шинээр 18.3 мянган төгрөгний НДШимтгэлийн илүү төлөлтийн авлагатай гарсан байна.

Бараа материалын үнэ шилжүүлэхдээ зардал тус бүрийн тооцооны дансаар дамжуулдаггүй байна.

Тооцоо нийлсэн актуудыг Дэм сүмбэр хоршоо, Мөнхийн шанд хоршоо, Дархан ник ХХК, Зүүн хараа цахилгаан шугам сүлжээ, Шуудан холбооны алба зэргүүдтэй тооцоо нийл бүрэн албажуулсан байна.

8. Цалингийн талаар

Цалин, үр дүнгийн урамшил, гэрээт ажилтны цалин зэрэгт нийт 111929.5 мянган төгрөгний төсөвт зардал батлагдсанаас гүйцэтгэлээр 111929.5 мянган төгрөгний цалин, хөлс, урамшил олгож батлагдсан батлагдсан зардлыг бүрэн зарцуулжээ.

Ажил олгогчоос төлөх НДШимтгэлд 12312.2 мянган төгрөг батлагдсанаас 12312.0 мянган төгрөгний НДШ-ийн зардал гарчээ.

Бидний дахин шалгалтын үр дүнд дээр дурдсан 8 хэсгүүдийн дотоод хяналтын ситем нь тухайн жилд хангалттай байсан ба нягтлан бодох бүртгэл нь Санхүүгийн тайлангийн зохистой үндэс болсон нь ажиглагдсан юм. Сайжруулах шаардлагатай байж болох хэд хэдэн санхүүгийн хяналтын талаар хавсралт бүхий удирдлагын захидалд тусгасан болно.

Аудитын явцад хийгдсэн гол шийдлүүд

Дараах хэсэгт Санхүүгийн тайлангийн аудит явцад гарсан гол асуудлуудыг хураангуйлан тэмдэглэсэн.

- + Зардлын бүлэг хооронд гүйлгэн шилжүүлэхдээ төрийн сангийн зөвшөөрлийг авч ЗЭБ-1 маягтаар баталгаажуулан гүйлгээ хийж байх
- + Хоорондын тооцоо бүрийг улирлын эцэст тооцоо нийлсэн актаар баталгаажуулж хэвших
- + Тооцоо бодолт, тооллогыг цаг тухай бүрд нь чанартай хийж гүйцэтгэж байх
- + Хөрөнгийг хүн тус бүрээр санхүүгийн программд картлаж, тооллогын бүртгэлийг программд шивж оруулан тооцоо бодсон актаар баталгаажуулж хэвших

Эдгээр асуудлуудыг ААГ болон Сүмбэр сумын цэцэрлэг авч үзэж хангалттайгаар шийдсэн. Бидний илрүүлсэн зүйлс болон дээрх санхүүгийн дотоод хяналтын талаар санал нь удирдлагын захидалд тусгагдсан байна. Санхүүгийн гүйлгээнүүд нь хүлээн зөвшөөрхүйц зохицуулагдсаныг тэмдэглэсэн.

Залруулагдаагүй алдаа

Аудитын стандарт нь Аймгийн Аудитын газарт аудитын явцад илэрсэн тодорхой биш болон залруулагдаагүй алдаанд анхаарал тавихыг шаарддаг.

Тайлбар мэдүүлгийн захидал

Аудитын үйл явцад Аймгийн Аудитын газар хөндлөнгийн аудиторын хувьд удирдлагын зүгээс гаргасан баталгаанд тулгуурлах ёстой байсан ч хараат бус байдлын хувьд энэ батламжийг дагах нь зохистой байсангүй. Аудитын гүйцэтгэл бүрд цэцэрлэгийн удирдлагаас эдгээр батлагааг бичгээр баталгаажуулан олж авахыг хүсч байна.

Аудитын санал дүгнэлт

Аймгийн Аудитын газраас тус тайланд зөрчилгүй санал дүгнэлт гаргахаар санал оруулж байна.

Үндэсний Аудитын Газрын харьяа

Төв Аймгийн Аудитын Газар

2014.03.14